


Баян Өлгий аймгийн 2024 оны 10 дугаар сарын гадаргын

усны чанарын тойм

1. Гадаргын усны чанар

Баян Өлгий аймгийн Ховд голын дагуух усны чанарын хяналт шинжилгээнийцэгүүдэд хөтөлбөрийн дагуу Ховд-Өлгий дээд, Ховд-Өлгий доод, Ховд-Баяннуур, Буянт-Дэлүүн, Сагсай-Буянт цэгүүдээс 2024 оны 10 дугаар сарын 06-09 ны өдрүүдэд дээж авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо.

5 цэгийн усны цахилгаан дамжуулах чанарын сарын өөрчлөлтийг 2023оны 1-12, 2024оны 10 дугаар сарын байдлаар Зураг 1-т харууллаа.



Зураг1 Голын дагуух цэгүүдийн усныцахилгаан дамжуулах чанар

2024 оны 10 дугаар сард Өлгий хотоос дээших Ховд-Өлгий дээд цэгт усны цахилгаан дамжуулах чанар /ЦДЧ/ 143.0 мкСи/см, Өлгий хотоос дооших Ховд-Өлгий доод 151.0 мкСи/см, Буянт-Дэлүүн 235.0 мкСи/см, Согоог Хөх-Хөтөл цэгт 299.0мкСи/см байна.

Хүснэгт1. Усны гол ионуудын агууламж

Харуул	Хатуу лаг, мг-экв/л	Ca, мг/л	Mg, мг/л	K+Na, мг/л	SO4, мг/л	Cl, мг/л	HCO3, мг/л	Эрдэсжилт, мг/л
Ховд- Өлгий дээд	1.10	14.8	4.4	13.8	12.9	4.6	76.3	126.8
Ховд- Өлгий доод	1.08	14.4	4.4	14.8	13.3	4.6	76.9	128.4
Буянт-Дэлүүн	0.84	9.6	4.4	21.8	11.6	5.0	81.1	133.6
Согоог-Хөх-Хөтөл	1.52	16.8	8.3	26.3	14.6	6.4	126.9	199.5
MNS4586:98					100	300		


Ховд голын дагуух дээд,доод, Баяннуур, Буянт-Дэлүүн, Сагсай-Буянт хяналт шинжилгээний цэгүүдэд ерөнхий хатуулагийг А.Е.Посоховын ангиллаар авч үзэхэд 1.5 мг-экв/л-ээс бага байгаа нь “маш зөөлөн ус” ангилалд орж байна.

Хүснэгт 2. Усны биогенийн нэгдлүүдийн агууламж


Харуул	Ph	УХ, мг/л	БХХ5 , мг/л	ПИЧ мг/л	НН4, мг/л	NO3, мг/л	NO2, мг/л	P, мг/л
Ховд- Өлгий дээд	7.8	8.16	0.9	1.7	0.08	0.08	0.005	0.004
Ховд- Өлгий доод	7.75	8.32	0.9	1.8	0.09	0.08	0.005	0.006
Буянт-Дэлүүн	7.9			2.4	0.14	0.11	0.007	0.026
Согоог-Хөх-Хөтөл	7.84			3.0	0.19	0.16	0.009	0.016
MNS4586:98		4.00<	3.0		0.50	9.00	0.020	0.100

Тайлбар:УХ-Ууссан хүчилтөрөгч;Бхх5-Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч

Ховд-Өлгий дээд, Ховд-Өлгий доод, Ховд-Баяннуур, Буянт-Дэлүүн, Согоог-Хөх-Хөтөл цэгүүдээс биогенийн нэгдлүүд Монгол улсын гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламж давсан тохиолдол гараагүй.



Зураг2. Усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж



Зураг3. Усны Аммоний агууламж/НН4/

2. Өлгий хотын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжын усны хяналт шинжилгээ


2024 оны 10 дугаар 09-ны өдөр Баян Өлгий аймагийн хаягдал ус цэвэрлэх СУАТ цэвэрлэх байгууламж /ЦБ/-ийн хаягдал бохир ус орж байгаа болон цэвэршүүлээд гаргаж байгаа цэгүүдээс нийт 2 сорьц авч хийсэн шинжилгээний дүнг MNS4953:2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн буй орчинд нийлүүлж болох хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/- тэй харьцуулан Хүснэгт 3-т үзүүлээ.

Хүснэгт 3. Өлгий хотын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн биогенийн агууламж


Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж	Сорьц авсан цэг	pH	Ж/б, мг/л	БХХ ₅ , мг/л	ПИЧ, мг/л	NH ₄ , мг/л	NO ₂ , мг/л	NO ₃ , мг/л	Цэвэршилт, %
СУАТ ЦБ	Гарах	7.68	57	72	64	8.85	0.096	0.89	18.2%
	Орох	7.23	81	88	80				
MNS 4943:2015		6-9	30.0	20.0	20.0	15.00			

Шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус 18,2%-ийн цэвэршилттэй байсан.

СУАТ цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар, жинлэгдэх бодисын сарын өөрчлөлтийг 2023 оны 3-11, 2024 оны 10 дугаар сарын байдлаар зураг 4-5-р зурагт харууллаа.



Зураг 4. СУАТ цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар



Зураг 4. СУАТ цэвэрлэх байгууламжийн жинлэгдэх бодис

Дүгнэлт:

Ховд голын усанд 2024 оны 10 дугаар сард хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд Ховд голын усны эрдэсжилт 143.0-151.0мг/л-т хэлбэлзэж байна.

Ховд голын ууссан хучилтөрөгчийн горим Өлгий хотоос дээш болон дооших цэгүүдэд Монгол улсын гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламжаас даваагүй голууд бохирдолгүй, цэвэр байсан байна.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын “Суат” ХХК-ны Цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгийн хаягдал усны шинжилгээний дүнгээс үзэхэд Өлгий сумын “Суат” ХХК-ны цэвэрлэх байгууламжийн бохир ус нь MNS4943:2015 стандарт дах зөвшөөрөгдөх дээд агууламжтай харьцуулахад перманганатын исэлдэх чанар 3.2 дахин давсан БХХ₅, 3.6 дахин жинлэгдэх бодис 1.9 дахин давсан үзүүлэлттэй байна.

Хаягдал ус цэвэршүүлэх байгууламж болох СУАТ ХХК нь 18.2%-тайгаар цэвэршүүлсэн усыг хөрсөнд шингээж механик аргаар цэвэршүүлж байна.

БАЯН- ӨЛГИЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ